


МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ.
Аюулгүй байдал, хамгаалалтын ажил үйлчилгээ.
Тавих ерөнхий шаардлага

MNS 6908 : 2021



Албан хэвлэл

Стандарт, хэмжил зүйн газар
Улаанбаатар хот
2021 он

Өмнөх үг

Стандарт, хэмжил зүйн газар (цаашид СХЗГ гэх) нь олон улсын стандартчиллын байгууллага (ISO)-ын гишүүн бөгөөд үндэсний стандартын төсөл боловсруулах ажлыг Монгол улсын стандартчиллын тогтолцооны суурь стандарт MNS 1-1, MNS 1-2 стандартын дагуу төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран хэрэгжүүлдэг.

СХЗГ нь үндэсний стандарт боловсруулах ажлыг холбогдох салбарын техникийн хороогоор дамжуулан гүйцэтгэдэг. Техникийн хорфодоор хэлэлцэн, дэмжигдсэн стандартын төслийг СХЗГ-ын даргын тушаалаар баталж, Монгол Улсын хэмжээнд хүчин төгөлдөр болно.

Стандартын төслийг нь холбогдох байгууллагууд буюу сонирхогч талуудаас саналыг авч тусгасан бөгөөд техникийн хорооны хуралд дээр гишүүдийн өгсөн санал, шүүмж зэргийг тусгасан болно.

Стандартын төслийг “Нийтлэг үйлчилгээний стандартчиллын техникийн хороо” /ТХ-24/-ны 2021 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн хурлаар хэлэлцүүлэн дэмжигдсэн.

СХЗГ-ын Ахлах мэргэжилтэн Н.Батжаргал (Ph.D) Монгол улсын стандартчиллын тогтолцооны суурь стандарт MNS 1-1:2006, MNS 1-2:2006-д нийцүүлэн хяnav.

Стандарт, хэмжил зүйн газар (СХЗГ)

Энхтайваны өргөн чөлөө 46А

Улаанбаатар Ш/Х – 48

Утас 266754, 263860 Факс (976-11) 458032

web: www.estandard.gov.mn,

E-mail: standardinform@masm.gov.mn

© СХЗГ, 2021

Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн дагуу энэхүү стандартыг бүрэн, эсвэл хэсэгчлэн хэвлэх, олшруулах эрх нь гагцхүү СХЗГ (Стандартчиллын төв байгууллага)-т байна.

АГУУЛГА

| | |
|---|-----------|
| Өмнөх үг | ii |
| Оршил | iv |
| 1 Зорилго | 1 |
| 2 Хамрах хүрээ | 1 |
| 3 Норматив эшлэл | 1 |
| 4 Нэр, томьёо тодорхойлолт..... | 2 |
| 4.1 Байгууллагад хамаарах ойлголт | 2 |
| 4.2 Үйлчилгээнд хамаарах ойлголт..... | 3 |
| 4.3 Баримт бичигт хамаарах ойлголт | 3 |
| 4.4 Хүний нөөц, мэргэжилд хамаарах ойлголт | 3 |
| 4.5 Хамгаалах байгууламж/үйл ажиллагаанд хамаарах ойлголт | 4 |
| 5 Ерөнхий шаардлага | 4 |
| 5.1 Байгууллагад тавих нийтлэг шаардлага | 4 |
| 5.2 Үйлчилгээнд тавих шаардлага | 6 |
| 5.3 Баримт бичигт тавих шаардлага | 7 |
| 5.4 Хүний нөөцийн хөгжилд тавих шаардлага..... | 8 |
| 5.5 Хамгаалах байгууламжид тавих шаардлага..... | 9 |
| 6 Дэмжлэг үзүүлэх үйлчилгээ | 10 |
| 7 Хяналт, шинжилгээ, үнэлгээ..... | 10 |
| А хавсралт(норматив) Байгууллагын зэрэглэлд тавих шаардлага..... | 11 |
| В хавсралт (норматив) Зэрэглэлд тавих эрхлэх үйл ажиллагааны хүрээнд хамаарах шаардлагатай хүний нөөцийн орон тоо..... | 12 |
| С хавсралт (норматив) Зэрэглэлд тавих эрхлэх үйл ажиллагааны хүрээнд хамаарах шаардлагатай хүний нөөцийн орон тоог гэрээгээр гүйцэтгүүлэх шаардлага | 13 |
| Д хавсралт (норматив) Байгууллагын зэрэглэл тогтооход тавих, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн иж бүрдэлд тавих шаардлага | 17 |
| Е хавсралт (норматив) Тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн иж бүрдэлд тавих жишиг шаардлага | 18 |
| F хавсралт (норматив) Байгууллагын хамгаалалтын ажилтны хувцас, тусгай хэрэгслийн хангарт, ашиглалт | 20 |
| G хавсралт (мэдээллийн) Дэмжих үйлчилгээ үзүүлсэн тухай акт..... | 21 |
| Ном зүй | 22 |

ОРШИЛ

Монгол Улс 1990 оноос зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэнээр шинэ тутам үүсэн байгуулагдаж буй хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагуудын аюулгүй байдлыг хангах, өмч хөрөнгийг гэмт халдлагаас хамгаалах явдал нийгмийн шаардлага болж тавигдсан. Энэ шаардлагыг хангах зорилгоор анхны гэрээт харуул хамгаалалтын байгууллага үүсэн байгуулагдсанаас хойш 30 гаруй жил өнгөрчээ. Энэ хугацаанд хувийн хэвшлийн харуул хамгаалалтын байгууллага, тэдгээрт ажиллагсдын тоо нэмэгдэж одоогоор 400 гаруй байгууллагад 10 000 орчим ажилтан ажиллаж байгаа гэсэн судалгаа буй.

Гэрээт харуул хамгаалалтын байгууллагууд тодорхой хүрээнд эвлэлдэн нэгдэж, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг бүрдүүлэх, үйлчилгээний нэгдмэл дүрэм журамтай болох, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах, гэрээгээр хүлээсэн үүргээ мэргэжлийн түвшинд найдвартай биелүүлэх баталгааг бий болгох талаар байнга анхаарч хамтарч ажиллаж ирсэн. Хувийн хэвшлийн харуул хамгаалалтын байгууллагын хэрэгцээ, шаардлагыг төрөөс анхааран үзэж, УИХ-аас 2000 онд “Гэрээт харуул хамгаалалтын тухай” хууль, 2001 онд “Хувийн хамгаалалтын тухай” хуулийг баталсан бөгөөд эдгээр хуулиудад нийцүүлэн холбогдох дүрэм, журмуудыг батлан гаргасан нь энэ салбарын үйл ажиллагааны эрх зүйн үндсийг бүрдүүлж байна.

Хуримтлуулсан туршлага, ололт амжилтад бататгах, ирээдүйн чиг хандлагаа тодорхойлох, үйлчлүүлэгчийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн найдвартай, шинэлэг үйлчилгээг үзүүлэх нь хамгаалалтын байгууллагуудын нэн тэргүүний зорилт байсаар ирсэн. Энэ зорилтыг хэрэгжүүлэхэд хамгаалалтын байгууллагын тогтолцоог бүрдүүлэх, зэрэглэл тогтоох, аюулгүй байдал хамгаалалтын ажлыг онол, арга зүйн үүднээс шинжлэх ухааны үндэстэйгээр зохион байгуулах, салбарын ажилтнуудын мэдлэг, чадварыг дээшлүүлэх, хөгжүүлэх, тэдний ажиллах нөхцөл, боломжийг сайжруулахад чиглэсэн, үйлчилгээний чанарт тавигдах шаардлагыг тогтоосон стандарт нэн чухал ач холбогдолтой юм. Зарим холбоод 10 гаруй жилийн өмнөөс хамгаалалтын ажил үйлчилгээний стандарт боловсруулах ажлыг эхлүүлсэн боловч нэгдсэн зохион байгуулалтгүйгээс удаашралтай, зогсонги байдалд байсан.

Энэ нөхцөл байдалд дүгнэлт хийж стандарт боловсруулах ажлыг эрчимжүүлэхийн тулд 2018 оны 5 дугаар сарын 24-ны өдөр Монголын Хамгаалалтын Ажилтны холбоо, Монголын Хамгаалалтын Байгууллагын холбоо,

Монголын Хамгаалалтын Байгууллагын Төв холбоо, Монголын Хамгаалагчдын Эрхийг Хамгаалах холбоо, Терроризмын Эсрэг Монголын нийгэмлэг ТББ-уудын төлөөлөл нэгдсэн хуралдаан зохион байгуулж, “Монголын хамгаалалтын холбоодын удирдах түр зөвлөл” /Ажлын хэсэг/-ийг байгуулсан билээ. Түр зөвлөл Стандарт хэмжил зүйн газартай ажил хэргийн холбоо тогтоон, мэргэжлийн зөвлөгөө, дэмжлэг авч хамтран ажилласнаар хэрэглэгчдэд зориулсан “Аюулгүй байдал, хамгаалалтын ажил үйлчилгээ” стандартын төслийг боловсруулж, бэлтгэсэн болно.

Стандартыг боловсруулахад ажил хэрэгчээр хандаж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч хамтарч ажилласан СХЗГ-ын холбогдох мэргэжилтнүүд, стандартын төсөлтэй танилцаж үнэтэй санал, зөвлөмж өгсөн төрийн болон төрийн бус байгууллагууд, төслийг шүүн хэлэлцэж дэмжсэн Нийтлэг үйлчилгээний стандартчиллын техникийн хорооны гишүүдэд нийт хамгаалалтын холбоодын өмнөөс гүн талархал илэрхийлье.

Одоо бидний өмнө энэхүү стандартыг сурталчлах, үйлчлүүлэгч бүрд таниulan ойлгуулах, үйл ажиллагаандaa мөрдлөг болгон хэвшүүлэх нь нэн тэргүүний зорилт болон тавигдаж байна. Салбарын үйл ажиллагаанд энэхүү стандартыг мөрдөх явцад хяналт шинжилгээ, үнэлгээ хийж ололттой ба дутагдалтай тал, агуулга, заалтуудыг тодорхойлж, 4 жилийн дараа буюу 2025 онд стандартыг дахин хянаж, шинэчлэхээр зорих болно. Шаардлагатай хэмээн үзсэн тохиолдолд хугацаа харгалзахгүй хянаж, шинэчлэх боломж нээлттэй юм.

Энэхүү стандартыг мөрдөж хэвшүүлснээр салбарын өмнө тулгарч буй зарим бэрхшээлийг шийдвэрлэх, аюулгүй байдал хамгаалалтын байгууллагуудын ажлын зохион байгуулалт, мэргэжлийн түвшин, үйлчилгээний чанар дээшлэх, ингэснээр салбарын нэр хүнд өсөж, үйлчлүүлэгчдийн итгэлийг улам батжуулах боломж нэмэгдэнэ гэж үзэж байна.

Иймд аюулгүй байдал хамгаалалтын ажил үйлчилгээ эрхэлдэг нийт байгууллагуудад хандан энэхүү стандартын хэрэгжилтийг хангаж, хамтарч ажиллахыг уриалж байна.

Монголын хамгаалалтын холбоодын удирдах түр зөвлөл

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 03.080.30

Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ.

Аюулгүй байдал, хамгаалалтын ажил үйлчилгээ.

Тавих өрөнхий шаардлага.

Services for consumers.

Security, protection services. General requirements.

Стандарт, хэмжил зүйн газрын даргын

СТАНДАРТЧИЛАЛ ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР

СТАНДАРТЫН

БОЛОВСРУУЛАГЧИД

MNS 6908 : 2021

олгосон хувь

2021 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн C/27

дүгээр тушаалаар батлав.

Бүрдэхүүний стандартын мөн болно

Энэхүү стандарт нь 2021 оны 07 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн хүчинтэй.

1 Зорилго

Аюулгүй байдал, хамгаалалтын ажил үйлчилгээ эрхлэгч хуулийн этгээдээс хэрэглэгчдэд үзүүлэх ажил үйлчилгээг хэвийн чанартай үзүүлэх, хүртээмжийг сайжруулах, зэрэглэл тогтоох үйл ажиллагаанд тавих шаардлага ба жишиг хэм хэмжээ тогтооход оршино.

2 Хамрах хүрээ

2.1 Төрийн тусгай хамгаалалт, зэвсэгт хүчин, цэрэг, тагнуул, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын харуул хамгаалалт ба хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр энгийн сахиул, манаач, жижүүрийн үүрэг гүйцэтгэхээс бусад аюулгүй байдал, хамгаалалтын ажил үйлчилгээ эрхэлж буй хуулийн этгээдэд хамаарна.

2.2 Аюулгүй байдал, хамгаалалтын байгууллага болон үйлчлүүлэгч нь энэхүү стандартын норматив шаардлагыг хангах, бусад этгээдтэй гэрээ байгуулах, ажил үйлчилгээ зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавихад мөрдлөг болгоно.

3 Норматив эшлэл

Энэхүү стандартад дараах эш татсан стандарт, баримт бичгүүдийг хэрэглэсэн. Он заасан эшлэлийн хувьд зөвхөн эш татсан хэвлэлийг хэрэглэнэ. Он заагаагүй эшлэлийн хувьд тухайн стандартын хамгийн сүүлийн хэвлэл (нэмэлтийн хамт)–ийг хэрэглэнэ.

MNS 6458, Химиин хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах, өрөнхий шаардлага;

MNS 5825, Орон сууц, олон нийтийн барилга. Өрөөний бичил уур амьсгалын үзүүлэлт;

MNS 5627, Цацрагийн хамгаалалт. Орон байрны агаар дахь родоны зөвшөөрөгдөх хэмжээ;

MNS 5566, Аж ахуй нэгж, байгууллага барилга байгууламжид гол унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага, норм;

MNS 5107, Биеийн хүчний ажлын ачааллыг үнэлэх үзүүлэлтийн норм, тодорхойлох арга;

MNS 5146, Цахилгааны аюулгүй ажиллагаа, Хамгаалах газардуулга тэлэлт;

MNS 5106, Мэдрэл сэктгэхүйн ачааллыг үнэлэх үзүүлэлтийн норм, тодорхойлох арга;

MNS 5010, Ажлын байрны агаар дахь тросны агуулгыг хэмжихэд тавигдах өрөнхий шаардлага;

MNS 6908 : 2021

MNS 5028, Ажлын байрны агаар дахь хорт бодисыг индикаторын гуурсаар тодорхойлоход тавих өрөнхий шаардлага;
MNS 5027, Дэлгэц бүхий тоног төхөөрөмжтэй ажиллах эрүүл ахуйн эргономик өрөнхий шаардлага;
MNS 4990, Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн ажлын байрны орчин эрүүл ахуйн шаардлага;
MNS 4244, Галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага;
MNS 5843, Хамгаалалтын дохиоллын тоног төхөөрөмжийн техникийн үндсэн үзүүлэлт, угсралт суурилуулалт, үйлчилгээнд тавих өрөнхий шаардлага;
MNS GOST R 12.2.143, Гал түймрийн үед нүүлгэн шилжүүлэх гэрэлтүүлэгч тэмдэг, тэмдэглэгээ, ангилал. Техникийн шаардлага. Хяналтын аргууд;
MNS 6423, Теле хяналтын системийн техникийн өрөнхий шаардлага.

4 Нэр, томьёо тодорхойлолт

4.1 Байгууллагад хамаарах ойлголт

4.1.1 Аюулгүй байдал, хамгаалалтын байгууллага

оноосон нэртэй, холбогдох хуульд заасан журмын дагуу эрх бүхий байгууллагад бүртгүүлсэн аж ахуйн нэгж байгууллага байна. Цаашид энэхүү стандартад "байгууллага" хэмээн товчоор дурдаж болно.

ТАЙЛБАР: Иргэн, аж ахуйн нэгжийн амь бие, эд хөрөнгөний халдашгүй, аюулгүй байдал ба хамгаалалтын үйлчилгээг хүрээлэн буй орчинд гэм хор учруулахааргүй техник хэрэгсэл ашиглах, хууль тогтоомжид заасан галт зэвсэг болон тусгай хэрэгсэл хэрэглэх, богино долгионы холбоо ашиглах болон гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, дүрс бичлэгийн болон дохиоллын хэрэгсэл ашиглах зөвшөөрөлтэйгээр үйл ажиллагаа эрхэлж байгаа хуулийн этгээдийг хэлдэг.

4.2 Үйлчилгээнд хамаарах ойлголт

4.2.1 Аюулгүй байдал, хамгаалалтын ажил үйлчилгээ

аюулгүй байдал, хамгаалалтын үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага гэрээний үндсэн дээр үйлчлүүлэгчийн амь бие, эрүүл мэнд, эд хөрөнгө, объектыг хамгаалах цогц үйл ажиллагааг. Цаашид "үйлчилгээ" гэнэ.

4.2.2 Үйлчлүүлэгч

гэрээний үндсэн дээр аюулгүй байдал, хамгаалалтын ажил үйлчилгээ хийлгэж байгаа хуулийн этгээд, хувь хүний.

4.2.3 Дохиолол хамгаалалт

объектод суурилуулсан дохиоллын техник хэрэгслээс дамжуулсан гал, хулгай, аюулын дохиог хүлээн авч боловсруулдаг, дохионы мөрөөр хариу арга хэмжээ авч аюулгүй байдлыг хангах, хоногийн 24 цагийн тасралтгүй ажиллагаатай хамгаалалтын үйлчилгээг.

4.2.4 Теле камерын хяналт

хамгаалалтын объектыг стандарт, шаардлагад нийцсэн теле камераар тоноглож нэгдсэн хяналтын төвд холбох, мэдээлэл, өгөгдөл, түүнийг дамжих дэд бүтцийн нууцлал, аюулгүй байдлыг хангасан байх үйлчилгээг.

4.3 Баримт бичигт хамаарах ойлголт

4.3.1 Хоногийн мэдээ

ажил үүрэг биелүүлсэн тухай, болсон үйл явдлын тэмдэглэл, объект хүлээлцэн гарын үсэг, санал бүхий тайланг.

4.3.2 Мэдэгдэл, шаардлага

болзошгүй эрсдэлээс сэргийлэх зорилгоор бусад байгууллага, хувь хүнд хандаж байгаа албан бичгийг.

4.4 Мэргэжилд хамаарах ойлголт

4.4.1 Бие хамгаалагч

гэрээний үндсэн дээр хамгаалуулагчийн амь бие, эрүүл мэндийг гэмт халдлагаас хамгаалах мэргэжлийн болон сэтгэл зүй, бие бялдарын бэлтгэлтэй, нууцыг чандлан хадгалах ёс суртахуунтай, шаардлагатай үед холбогдох хууль, журмын дагуу галт зэвсэг, тусгай хэрэгсэл, холбоо, техникийг ашиглан халдлагыг таслан зогсоох, аюулгүй байдлыг хангах чиг үүргийг гүйцэтгэж байгаа ажилтныг.

4.4.2 Хамгаалалтын ажилтан

тухайн объектод нэвтэрч буй хүн, тээврийн хэрэгсэл, ачаа бараа, эд зүйлсийг шалгах, оруулах, гаргах, гэнэтийн аюултай нөхцөл үүсэхээс сэргийлэх, үйл ажиллагааны нууцыг хадгалах, нийтээр дагаж мөрдөх хууль, тогтоомж, дотоод дүрэм, журмын хэрэгжилтийг сахиулах, үүсэж болзошгүй эрсдэл, халдлага, хулгай, хорлон сүйтгэх үйлдлээс хамгаалах үүрэг гүйцэтгэж байгаа ажилтныг.

4.4.3 Дохиолол хамгаалалтын ажилтан

объектын эрсдэлийг үнэлэх, дохиолол хамгаалалт, төле хяналтын тоног төхөөрөмжийн тооцоо гаргах, объектод угсрах, суурилуулах, ажиллагааны горимын тохиргоо хийх, гэмтлийг илрүүлэх, засвар үчилгээ хийх, дохиолол мэдээллийн төвтэй холбох, найдвартай ажиллагааг хангах үйл ажиллагааг гүйцэтгэж байгаа ажилтныг.

4.4.4 Шуурхай бүлэг /ажилтан/

объектоос илэрсэн /гал, хулгай, аюулын/ дохионы мөрөөр уг объект дээр шуурхай хүрэлцэн очиж аюулгүй байдлыг хангах үүрэг бүхий бүлэг /ажилтан/.

4.4.5 Аюулгүй байдлын ажилтан

аюулгүй байдал, хамгаалалтын байгууллагад аюулгүй байдлын чиглэлээр тодорхой үүрэг гүйцэтгэж буй этгээдийг.

4.4.6 Мэргэжлийн зөвлөл

аюулгүй байдал, хамгаалалтын байгууллага, ажилтны ажил үйлчилгээ стандарт шаардлагад нийцэж буй эсэхийг хянаж үнэлэх эрх бүхий төрийн ба төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын төлөөллөөс бүрдсэн бүрэлдэхүүнийг.

4.4.7. Хяналтын оператор

объектод суурилуулсан дохиолол, төле камер, бусад хяналтын тоног төхөөрөмж ашиглан хяналт тавьж, зохицуулалт хийж байгаа ажилтныг.

4.5 Хамгаалах байгууламж ба үйл ажиллагаанд хамаарах ойлголт

4.5.1. Шалган нэвтрүүлэх

объектод хүн ба тээврийн хэрэгсэл, ачаа тээш, бараа материалыг шалган нэвтрүүлэх үйлчилгээг.

4.5.2. Объект

хамгаалалтад авсан хүн, барилга байгууламж, бусад зүйлд хамаарах тодорхой орчин, газар нутгийг.

4.5.3. Хамгаалалтын цэг [пост]

ажиглах, хянах, шалгах, нэвтрүүлэх, журам сахиулах албан үүрэг гүйцэтгэх хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн шаардлага хангасан ажлын байрыг.

4.5.4. Хамгаалалтын бүс

ажиглах, хянах, шалгах, аюулгүй байдлын үйл ажиллагаа явуулах, хөдөлгөөнт эргүүлийн, хариуцах хэсгийн хүрээ хязгаарыг.

4.5.5. Онцгой хамгаалалтын бүс

хамгаалах байгууламж ба аж ахуйн нэгж, байгууллагад гоц халдварт, цар тахал өвчин гарсан үед үйлчлүүлж буй иргэд болон ажиллагсдыг тусгаарлах хэсгийн хүрээ хязгаарыг.

4.5.6. Камерын хяналтын цэг

объектыг хянах зорилгоор байгуулсан теле камерын хяналтын төвийг.

4.5.7. Хяналтын орчин

хяналтын камерын оптик дурангийн харагдах өнцгөөр хянагдаж буй орон зайг.

5 Ерөнхий шаардлага

Аюулгүй байдал, хамгаалалтын байгууллага нь Монгол Улсын холбогдох хууль, эрх зүйн актад дурдсан шаардлагуудыг ханган ажиллах эрх зүйн болон санхүүгийн бүрэн чадамжтай, тухайн ажил үйлчилгээгээр мэргэшсэн байхыг шаардана.

5.1 Байгууллагад тавих нийтлэг шаардлага

5.1.1 Оноосон нэртэй, монгол улсын холбогдох хуулийн этгээдэд бүртгүүлсэн, салбарын эрх бүхий байгууллагын зохих зөвшөөрөлтэй байна.

5.1.2 Аюулгүй байдал, хамгаалалтын байгууллага нь үйл ажиллагааны ангилал, төрлөөр дагнасан буюу нэгдмэл цогц байдлаар үйлчилгээг эрхэлж болно:

- a) Гэрээт харуул хамгаалалт,
- b) Хувийн хамгаалалт,
- c) Дохиоллын хамгаалалт, суурилуулалт, засвар үйлчилгээ,
- d) Сургалтын,
- e) Аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх,
- f) Аюулгүй байдлын зөвлөх үйлчилгээ,
- g) Камерын хяналт, суурилуулалт, засвар үйлчилгээ
- h) Радио станц, дахин дамжуулах станцын суурилуулалт,
- i) Төрөлжсөн засвар үйлчилгээ,
- j) Бусад.

5.1.3 Байгууллагыг үйл ажиллагааны ангилал, төрөл тус бурд нь энэхүү стандартын шаардлага ба мэргэшсэн байдлаар нь дараах зэрэглэл тогтооно./А хавсралт/

- a) "A" зэрэглэлийн байгууллага,
- b) "B" зэрэглэлийн байгууллага,
- c) "C" зэрэглэлийн байгууллага.

5.1.4 Байгууллагын зэрэглэл нь энэхүү стандартын шаардлагууд ба "A", "B", "C", "D" хавсралтуудын норматив шаардлагыг хангасан байна.

5.1.5 Байгууллага нь мэдээллийн бие даасан дотоод сүлжээтэй байх ба сүлжээний аюулгүй байдал, нууцлалыг зохих эрх зүйн баримт бичиг, холбогдох байгууллагаас зөвлөсөн шаардлагад нийцүүлж, бүрэн хангасан байна.

5.1.6 Байгууллагын хэрэглэж буй техник хэрэгсэл, галт зэвсэг болон тусгай хэрэгсэл, дохиоллын төхөөрөмж нь ашиглах зааварчилгаатай, холбогдох байгууллагын зөвшөөрөлтэй байна. Энэ нь E хавсралтын дагуу байна.

5.1.7 Байгууллага нь эрх, үүргээ хэрэгжүүлэх бүтэц, зохион байгуулалт, мэргэжлийн болон мэргэшсэн хүний нөөц, зэвсэг, техник, тоног төхөөрөмж ба тусгай хэрэгслээр энэхүү стандартын холбогдох агуулгад дурдсан шаардлагыг хангасан байна. Энэ нь "B", "C", "D", "E" хавсралтын дагуу байна.

5.1.8 Байгууллага нь техник тоног төхөөрөмжийн заавар, удирдамжийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, орчин үеийн шаардлагад нийцүүлэн сайжруулан ажиллах төлөвлөгөөтэй байж, хэрэгжилтийг хангасан байхыг шаардана.

5.1.9 Аюулгүй байдлыг хангаж, хамгаалж байгаа эд хөрөнгө, объектын талаар шаардлагатай мэдээ, мэдээлэл авах, хамгаалах эд хөрөнгө, объект нь гэрээнд заасан нөхцөл шаардлагыг хангаагүй бол хүлээн авахаас татгалзах зэрэг агуулга нөхцөлийг дэлгэрэнгүй тусгасан гэрээг үйлчлүүлэгч талтай бичгээр байгуулсны үндсэн дээр ажил үйлчилгээг эрхэлнэ.

5.1.10 Аюулгүй байдал, хамгаалалтын ажилтныг эрх бүхий байгууллагаас баталсан загварын дүрэмт хувцас /F хавсралтад заасан шаардлагыг хангасан хугацаа нормоор/ бусад хэрэгслээр хангах, хууль эрх зүйн болон холбогдох сургалтад хамруулах, тусгай хэрэгсэл хэрэглэх зааврыг дагаж мөрдүүлэх, ёс зүй, харьцаа, хандлагыг төлөвшүүлэх, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний батлагдсан төлөвлөгөөтэй байж, хэрэгжилтийг хангасан байна.

5.1.11 Байгууллага нь ижил төрлийн үйлчилгээ үзүүлэгч дотоодын болон гадаадын байгууллагатай харилцан туршлага солилцох болон мэргэшүүлэх сургалтыг жилд 2-оос доoshгүй удаа зохион байгуулахаар төлөвлөж, биелэлтийг хангасан байна.

5.1.12. Байгууллагын эрсдэлийн үнэлгээ хийх, үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр мэргэшсэн мэргэжилтнийг ажиллуулна.

5.1.12.1 Аюулгүй байдал, хамгаалалтын ажилтны хамгаалж буй объектод аливаа эрсдэл гарахаас сэргийлэх зорилгоор төлөвлөгөөт болон тогтмол сургалт, мэдээллийг зохион байгуулна:

- a) Гэмт хэрэг, зөрчлөөс сэргийлэх,
- b) Галт зэвсэг болон тусгай хэрэгсэлтэй зөв харьцах,
- c) Объектод учирч болох эрсдэлт нөхцөл байдал, түүнээс сэргийлэх

d) Бусад.

5.1.13 Байгууллага нь гадаад улс орон болон адил төстэй үйл ажиллагаа явуулдаг байгууллагатай хамтран ажиллах туршлага солилцох, мэргэжил дээшлүүлэх ажлыг тогтмол зохион байгуулах тогтолцотой байна.

5.1.14 Байгууллагад мэргэшсэн хүний нөөцийн мэргэжилтнийг ажиллуулах ба "В", "С" хавсралтад дурдсан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

5.1.15 Байгууллагад мэргэжлийн нягтлан бодогч, хангамжийн ажилтныг ажиллуулах ба үйл ажиллагаа явуулахтай холбоотой ахуй, хангамж, үйлчилгээний хуваарь бүхий батлагдсан төлөвлөгөөтэй байж, хэрэгжилтийг ханган ажиллахыг шаардана. Энэ нь "D", "E", "F" хавсралтад заасан шаардлагыг хангасан байна гэж ойлгогдоно.

5.2 Үйлчилгээнд тавих шаардлага

5.2.1 Үйлчлүүлэгч этгээдийн эрх зүйн байдал, зан заншил, үнэт зүйлс, үндэс угсаа, нийгмийн гарал үүсэл, итгэл үнэмшилд хүндэтгэлтэй хандаж, шашин шүтлэг, хувийн нууцыг чандлан хадгалж, бусдад задруулахыг хориглоно.

5.2.2 Үйлчлүүлэгч талтай хамтран ажиллах гэрээг хууль, эрх зүйн акт, энэхүү стандартад нийцүүлэн байгуулна.

5.2.3 Ажилтны бие махбод ба сэтгэл зүйн тогтвортой байдлыг хадгалах, эрүүл мэндийг хамгаалах зорилгоор ажил үүрэг гүйцэтгэх ачаалал, хугацааг энэ стандартын 5.5.3, 5.5.4, 5.5.5-д заасан утгаас хэтрүүлэхийг хориглоно.

5.2.4 Аюулгүй байдал хамгаалалтын ажил үйлчилгээ нь урьдчилан сэргийлэх, хяналт тавих, зөрчлийг таслан зогсоох эрхийг агуулах ба хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагаас бусад тохиолдолд үйлчлүүлэгчээс үл хамаарах байдлаар үйл ажиллагаагаа зохион байгуулна.

ТАЙЛБАР: Тухайн гэрээ байгуулсан үйлчлүүлэгч байгууллагын ажилтнуудаас тусдаа байгууламжид амрах, хувцсаа солих боломж нөхцөлтэй байж, хооллох цагийг зөрүүлэх гэх мэт асуудлуудыг тодорхой шийдсэн байхыг шаарддаг.

5.2.5 Эрх бүхий байгууллагын шаардсан үйл ажиллагаатай холбоотой мэдээ мэдээлэл, тайланг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, тушаалын дагуу цаг хугацаанд нь үнэн зөв, шуурхай, ил тод, тогтмол мэдээлж байна.

5.2.6 Холбогдох байгууллага болон үйлчлүүлэгчдийн хүсэлтээр аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг хийх чадвартай байна.

5.2.7 Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангахад Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа холбогдох эрх зүйн баримт бичигт дурдсан шаардлага, заавар стандарт болон холбогдох дүрэм, журам, зааврыг мөрдөж ажиллана.

5.2.8 Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд аюулгүй байдлын хяналт-шинжилгээ үнэлгээ хийж зөвлөмж, мэдэгдэл, шаардлага хүргүүлнэ.

5.2.9 Үйлчлүүлэгчид аюулгүй байдлын ажил үйлчилгээ, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн дүрэм дотоод журам, зааврын хэрэгжилтийн талаар тодорхой

мэдээлэл өгч, байгууллагын аюулгүй байдлыг хангах нөхцөл бололцоог бүрдүүлэхийг шаардана.

5.2.10 Үйлчлүүлэгчид эд зүйл, өмч хөрөнгө гэмт халдлага, гамшиг осол, гал түймэрт өртөхөөс урьдчилан сэргийлэх санамж сэрэмжлүүлгийг тогтмол өгч, аюулгүй орчин бүрдүүлэх хүн хүч, камер дохиолол, техник хангамжийн талаар мэдэгдэл, шаардлага өгч идэвхтэй арга хэмжээг тухай бүр авч, хэрэгжүүлсэн байна.

5.2.11 Дохиоллын хамгаалалттай объектыг нээх, хаах, дохио илэрсэн үед дохиоллын компаний талран ажиллуулах зорилгоор 1-ээс 10 хүртэлх итгэмжлэгдсэн төлөөлөгч томилон ажиллуулах бөгөөд тэдний тухай мэдээллийг хэрэглэгчийн хуудсаар баталгаажуулах. Итгэмжлэгдсэн төлөөлөгч нь баталгааны хуудсанд заагдсан заалтуудтай танилцан гарын үсэг зурж баталгаажуулах тогтолцоотой байна.

5.2.12 Итгэмжлэгдсэн төлөөлөгчийг нэмэх хасах, нууц кодыг өөрчлөх, объектыг хамгаалалтаас гаргах, объектыг түр хугацаагаар хяналтаас салгах хүсэлтээ үйлчлүүлэгч тал аюулгүй байдал, хамгаалалтын байгууллагад албан бичгээр гаргах ба нууцлалын зааварчилгааг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгосон байна.

5.3 Баримт бичигт тавих шаардлага

5.3.1 Байгууллага нь архив, бичиг хэргийн талаар гарсан холбогдох журам зааврын биелэлтийг хангасан байхыг шаардана.

5.3.2 Байгууллагын хэрэглэж буй техник хэрэгсэл, галт зэвсэг болон тусгай хэрэгсэл, дохиоллын төхөөрөмж нь цаасан болон цахим хяналтын бүртгэлтэй байна.

5.3.3 Байгууллага нь үйл ажиллагааны эрхэлж буй үйлчилгээний төрөл бүрээр эрсдэлийн үнэлгээг хийж, эрсдэлээс сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөөтэй байна.

5.3.4 Болзошгүй гамшиг, онцгой байдлын үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээ авах тухай батлагдсан төлөвлөгөөтэй байна.

5.3.5 Статистик, бүртгэл, хяналт, тайлангийн мэдээллийн болон бусад зориулалтын программ хангамжтай байх бөгөөд шаардлагатай мэдээний санг үүсгэж баяжилтыг тогтмол хийж хэвшсэн байна.

5.3.7 Үйлчлүүлэгч, хэрэглэгчийн сэтгэл ханамж, үйлчилгээний чанарт үнэлгээ хийх зорилгоор судалгаа, санал хүсэлтийг цаасан болон цахим хэлбэрээр авах, түүнийг шийдвэрлэх тогтолцоо бүхий тусгай журамтай байна.

5.3.8 Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үүднээс гарсан хэрэг зөрчлийн бүртгэл хөтөлсөн, шалтгаан нөхцөлийг арилгах арга хэмжээ авсан байна.

5.3.9 Үйлчлүүлэгчид урьдчилан сэргийлэх санамж сэрэмжлүүлэг өгч, аюулгүй орчин бүрдүүлэх талаарх мэдэгдэл, шаардлага хүргүүлнэ.

5.3.10 Мэдээ тайланг цаасан ба цахим хэлбэрээр холбогдох хууль, дүрэм, журам зааврын дагуу зохих ёсоор архивлан хадгалж байна.

5.4 Хүний нөөцийн хөгжилд тавих шаардлага

5.4.1 Ажилд шинээр орс хиргэн нь эмнэлгийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан байх ба мэргэжлийн эмч болон эрүүл мэндийн байгууллагын баталгаажуулсан эрүүл мэндийн хуудсыг үндэслэн ажилд томилсон байхыг шаардана

5.4.1.1 Аюулгүй байдал, хамгаалалтын ажилтныг 2 жил тутамд эрүүл мэндийн үзлэгт хамруулсан байна.

5.4.2 Хууль зүй, Хөдөлмөр болон Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүдийн хамтран баталсан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу аюулгүй байдал, хамгаалалтын ажилтны сургалтын төлөвлөгөөтэй байж, биелэлтийг хангасан байна.

5.4.3 Шинэ ажилтанд байгууллагын үйл ажиллагааг танилцуулах, чиглүүлэх, дасан зохицох болон мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх сургалтыг зохион байгуулах тогтолцоотой байна.

5.4.4 Ажилтны сургалтын хөтөлбөр нь аюулгүй байдлын үйлчилгээ үзүүлэх чадамж болох гэмт хэрэг ба зөрчил, гол түймэр, гамшиг ослоос хамгаалах, эмнэлгийн анхан шатны болон амилуулах тусламж үзүүлэх, өөрийгөө эрсдлээс хамгаалах мэдлэг чадвар эзэмшиүүлэхэд чиглэсэн байна.

5.4.5 Ажилтны хууль эрх зүйн мэдлэг, аюулгүй байдал, хамгаалалтын онол арга зүйн мэдлэг, бие бялдрын хөгжил, сэтгэл зүйн байдал, хандлагыг үнэлэх, мэргэжлийн ур чадварын түвшин тогтоо ажлыг үр дүнтэй тогтмол зохион байгуулах батлагдсан төлөвлөгөө удирдамжтай байж, биелэлтийг хангасан байхыг шаардана.

5.4.6 Аюулгүй байдал, хамгаалалтын үйл ажиллагааг биечлэн гүйцэтгэх боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах, мэргэжлийг нь дээшлүүлэх сургалтыг Хууль зүй, Хөдөлмөр болон Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүдийн батлан гаргасан хөтөлбөрийн дагуу сургалтын эрх бүхий байгууллага зохион байгуулж, гүйцэтгэл үр дүнг цагдаагийн болон зохих мэргэжлийн байгууллагын төлөөллийг оролцуулсан, “Мэргэжлийн зөвлөл” хариуцна (С.4 хавсралтын дагуу).

5.5 Ажлын байр ба үйл ажиллагаанд тавих шаардлага

5.5.1 Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн шаардлагыг хангасан байгууламж ба нөхцөлд үйл ажиллагааг эрхлэн явуулна.

5.5.2 Аюулгүй байдал, хамгаалалтын ажилтныг хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн шаардлага хангасан ажлын байр, галт зэвсэг, тусгай хэрэгсэл, бичиг баримтыг хадгалах шүүгээ сейфээр хангасан байна.

5.5.3 Ажил үйлчилгээний төрлөөс хамаарч 1-р хүснэгтэд заасан норматив хэм хэмжээг мөрдлөг болгоно.

1-р хүснэгт- Ажил үйлчилгээний төрлүүд, тэдгээрийн нөхцөлөөс хамаарах норматив

| д/д | Ажил үйлчилгээний төрөл | Мөрдөх хэм хэмжээ |
|-----|-----------------------------|---|
| 1. | Ажиглалт хийх, хяналт тавих | -Хамгаалалтын цэгээс ажиглалт хийх, хамгаалалтын бүсийг 400 метрээс хэтрүүлэхгүй байх. -Ил задгай бараа материал техник хэрэгслийг тусгайлсан хашаагүй бол 2500 м.кв талбайгаас хэтрүүлэхгүй байх -Барилга байгууламж /давхар/-ийн бүх хэсгийг бүрэн хянах боломжтой байдлаар хамгаалалтыг хүн/хяналт дохиоллын техник хосолсон хэлбэрээр зохион байгуулах. |
| 2. | Хөдөлгөөнт эргүүл | -Хөдөлгөөнт эргүүл газар орны байдлаас шалтгаалан өдрийн цагт 800 м-ээс ихгүй холын зайд, шөнийн цагт 400 м-ээс хэтрэхгүй холын зайдтай байхаар хариуцах хэсгийг тогтоох. -Тээврийн хэрэгслээр албан үүрэг гүйцэтгэх тохиолдолд хариуцах хэсэг тогтоохгүй. |
| 3. | Шалган нэвтрүүлэх | - Нэг шалган нэвтрүүлэгч нь хоногт 700-аас ихгүй хүн шалгахаар тооцно. Хэрэв үүнээс их ачаалалтай байвал тухайн цэгт ажиллах шалган нэвтрүүлэгчийн тоог нэмнэ. -Хүн ба тээврийн хэрэгслийг нэвтрүүлэх нэг цэгт 2-оос доoshгүй ажилтан хамт байхаар тогтооно. - Тэсэрч дэлбэрэх бодисын үйлдвэр, агуулахын хамгаалалтыг шалган нэвтрүүлэх ба өндрийн хяналт хосолсон байхаар тооцож, галт зэвсэг эзэмших эрх бүхий ажилтан ажиллуулна. |
| 4 | Хяналтын оператор | Хяналтын оператор нь 10/14 эсвэл 8/16 горимоор 4 ээлжээр үүрэг гүйцэтгэнэ. Хяналтын оператор нь хоногийн мэдээний дэвтрээс гадна обьектоос бүртгэгдсэн нээлт, халт, тест, түгшүүр, тэжээл тасралт, сэргээлтийг бүртгэх “хяналтын хуудас”ыг хөтөлж, хяналт тавин ажиллана. |

5.5.4 Аюулгүй байдал, хамгаалалтын ажилтны ээлжийн хуваарийг сард 180 цагаас хэтрэхгүй байхаар тогтоосон байхыг шаардана.

5.5.5 Бие хамгаалагчийн албан үүрэг гүйцэтгэх хугацаа нь 1 хоногт 10 цагаас хэтрэхгүй байхаар зохицуулна. Бие хамгаалагчийн ажил хоорондын унтаж амрах хугацаа нь 1 хоногт 8 цагаас багагүй байна.

5.5.6. Аюулгүй байдал хамгаалалтын ажилтан албан тушаал, хувийн мэдээллийг дурдсан албаны үнэмлэхтэй байна.

6 Дэмжлэг үзүүлэх үйлчилгээ

6.1 Байгууллага нь нийгмийн хариуцлагын хүрээнд гал түймэр, гамшиг осол, халдварт өвчин, нийтийг хамарсан арга хэмжээний үед авч хэрэгжүүлж буй үйл ажиллагааг дэмжин ажиллах санамж бичгийг холбогдох эрх бүхий байгууллагатай байгуулсан байна.

6.2. Холбогдох хууль тогтоомжид зааснаар эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэр, хүсэлтийн дагуу эрхэлж байгаа үйл ажиллагаагаар дэмжих ба G хавсралтад дурдсан ёсоор бүртгэл мэдээллийг хөтөлж, эрх бүхий этгээдээр баталгаажуулсан байна.

6.3 Үйлчлүүлэгч байгууллага, иргэн аюулгүй байдлын зөвлөгөө авах хүсэлт гаргасан тухай бүр үйлчилгээ үзүүлэх ба шаардлагатай тохиолдолд ямар байгууллагад хандахыг чиглүүлж өгнө.

6.4 Үйлчлүүлэгч болон бусад байгууллагын хүсэлтээр аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг төлбөртэй болон төлбөргүйгээр хийж болно.

7 Хяналт, шинжилгээ, үнэлгээ

7.1 Энэхүү стандартын хэрэгжилтэд дотоод хяналт шинжилгээ-үнэлгээг мэргэжлийн зөвлөлөөр тогтмол хийлгэж, гаргасан дүгнэлт зөвлөмжийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж ажиллана.

7.2 Үйл ажиллагааны хүртээмж, чанар, аюулгүй байдал болон хууль тогтоомж, дүрэм журам, зааврын хэрэгжилтэд тогтмол дүн шинжилгээ үнэлгээ хийж, үр дүнг тооцон ажиллана.

7.3 Ажилтны ёс суртахуун, ёс зүй, харьцаа, хандлага, мэдлэг, ур чадварт үнэлгээ өгч урамшуулал, хариуцлагын тогтолцоог хэрэгжүүлнэ.

7.4 Үйлчлүүлэгчийн эрэлт хэрэгцээ, гаргасан гомдол, санал хүсэлтийн мөрөөр хяналт тавьж ажиллана.

7.5 Хяналт шинжилгээ үнэлгээ хийсэн ажлын үр дүнгийн тайланг холбогдох баг, алба, хэсгээр хэлэлцүүлж, нийт ажилтан, үйлчлүүлэгч болон холбогдох байгууллагад нээлттэй мэдээлнэ.

7.6 Байгууллагын хүсэлт буюу ажилтан эсвэл үйлчлүүлэгч этгээдээс гаргасан санал, мэдээлэл, гомдлын дагуу “Мэргэжлийн зөвлөл” зохих шийдвэрийг гарган танилцуулдаг байна.

7.7 “Мэргэжлийн зөвлөл” нь байгууллагад стандартын зэрэглэлийг олгохдоо тухайн байгууллага гэрээт харуул хамгаалалтын тухай болон хувийн хамгаалалтын тухай хууль, холбогдох журам заавар, энэхүү стандартад үйл ажиллагаа нь нийцэж буй эсэхэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж “А” хавсралтад заасны дагуу зэрэглэл тогтооно.

ТӨГСӨВ.

**А хавсралт
(норматив)**

Байгууллагын зэрэглэлд тавих шаардлага

| Д/Д | Зэрэглэлийн ангилал | Ерөнхий шаардлага ба үндэслэл |
|-----|-----------------------------------|--|
| 1. | “A” зэрэглэлийн байгууллага | Тухайн байгууллага нь 10-аас дээш жил аюулгүй байдал, хамгаалалтын ажил үйлчилгээг мэргэжлийн төвшинд тогтвортой эрхэлж байгаа, байнгын болон шуурхай ажиллагааны мэргэшсэн бүрэлдэхүүн, зэвсэг техниктэй, үндсэн бүрэлдэхүүний 60-аас доошгүй хувь нь мэргэжлийн шаардлагыг хангасан, төлөвлөгөөт сургалтын материаллаг бааз, санхүү эдийн засгийн чадавхтай байна. |
| 2. | “B” зэрэглэлийн байгууллага | Тухайн байгууллага нь 6-аас 10 хүртэлх жил аюулгүй байдал, хамгаалалтын ажил үйлчилгээг тогтвортой эрхэлж, мэргэшиж байгаа, 50-аас доошгүй хувь нь мэргэжлийн шаардлагыг хангасан байна. |
| 3. | “C” зэрэглэлийн байгууллага | Тухайн байгууллага нь 5 хүртэлх жил аюулгүй байдал, хамгаалалтын ажил үйлчилгээг тогтвортой эрхэлж, мэргэшиж байгаа, 40-өөс доошгүй хувь нь мэргэжлийн шаардлага хангасан байна. |

1-Р ТАЙЛБАР: Энэхүү хүснэгтээр үйл ажиллагаа явуулсан хугацаа нь зэрэглэл тогтоох ерөнхий үндэслэл болно.

2-Р ТАЙЛБАР: Үйлчлүүлэгч байгууллага, иргэний аюулгүй байдлыг хангах ажил үйлчилгээг эрхлэх аюулгүй байдал, хамгаалалтын байгууллагыг бүтэц зохион байгуулалт, хүний нөөц, үйлчилгээний чадамж, дадлага туршлага, мэргэжлийн ажил үйлчилгээг явуулж байгаа түвшин, техник тоног төхөөрөмж, эдийн засгийн чадамж хангамжаас хамаарч зэрэглэлийг үйл ажиллагаа явуулсан хугацаанаас үл хамааруулан тогтоож болно.

В хавсралт
(норматив)

Зэрэглэлд хамаарах, шаардлагатай хүний нөөц

B.1 Байгууллага зэрэглэлийн шаардлагад нийцсэн B.1 хүснэгтээр тогтоосон хүний нөөцтэй байна.

B.1.1 Аюулгүй байдал, хамгаалалтын ажилтан/захиргаа, аж ахуйн үйлчилгээний ажилтны харьцаа нь 80/20 гэсэн харьцаатай байхыг шаардана.

B.1.2 Байгууллагын зэрэглэлээс хамаарч энэхүү хүснэгтэд заасан үйл ажиллагааны чиглэлээр ажиллах үндсэн ажилтны орон тооны доод хязгаарыг тогтоох ба гэрээгээр гүйцэтгүүлж болох үйл ажиллагааны чиглэл нь С хавсралтад дурдсан шаардлагыг хангасан байна.

B.1 хүснэгт. Хүний нөөцөд тавих шаардлага

Хүний тоо

| № | Үйл ажиллагааны чиглэл | Орон тооны доод хязгаар | | |
|-----|--|--|-----------------------------------|-----------------------------------|
| | | "A" зэрэглэлийн байгууллага | "B" зэрэглэлийн байгууллага | "C" зэрэглэлийн байгууллага |
| 1. | Менежментийн үйл ажиллагаа | 5 | 2 | 1 |
| 2. | Эдийн засгийн төлөвлөлт, санхүү, нягтлан бodoх буртгэл | 2 | 1 | 1 |
| 3. | Дохиолол хамгаалалт, камерын хяналтын үйлчилгээ, | 2 | 1 | |
| 4. | Мэдээлэл, технологи, харилцаа холбооны үйлчилгээ. | 2 | 1 | |
| 5. | Компьютер, техник тооног төхөөрөмжийн засвар үйлчилгээ | Гэрээгээр гүйцэтгүүлж болно | Гэрээгээр гүйцэтгүүлж болно | Гэрээгээр гүйцэтгүүлж болно |
| 6. | Хүний нөөцийн менежер | 2 | 1 | |
| 7. | Сургалт | 2 | Гэрээгээр гүйцэтгүүлж болно | |
| 8. | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан мэргэжилтэн | 50 хүн тутамд 1 ажилтан | Гэрээгээр гүйцэтгүүлж болно | |
| 9. | Хангамж үйлчилгээ | 3 | 2 | 1 |
| 10. | Аюулгүй байдлын зөвлөгөө | 1 | Гэрээгээр гүйцэтгүүлж болно | Гэрээгээр гүйцэтгүүлж болно |
| 11. | Эрсдэлийн үнэлгээ | 1 | Гэрээгээр гүйцэтгүүлж болно | Гэрээгээр гүйцэтгүүлж болно |
| 12. | Аюулгүй байдал хамгаалалт | Үйл ажиллагааны онцлог, хэрэгцээ шаардлагаар тодорхойлогоно. | | |
| 13. | Алба, хэлтэс, нэгжүүдийн удирдлага | | | |

ТАЙЛБАР: Үйл ажиллагааны онцлогтой уялдуулан бусад мэргэшлээр үзүүлэх үйлчилгээний хэрэгцээ, ачаалал, технологи, дүрэм журам заавар, удирдамжид үндэслэн шаардлагатай ажилтан, бусад ажиллагсдын тоог тооцож, үндсэн орон тоог зохистойгоор бүрдүүлж ажиллана.

**С хавсралт
(мэдээллийн)**

**Зэрэглэлд хамаарах хүний нөөцийг
гэрээгээр гүйцэтгүүлэх шаардлага**

Сургалт, харилцаа холбоо, аж ахуй, хангамж зэрэг аюулгүй байдал, хамгаалалтын удирдлага зохион байгуулалт, дэмжих үйлчилгээний албан тушаалын ажилтныг ажлын ачаалал, хэрэгцээ шаардлагатай уялдуулан үндсэн орон тоон дээр болон гэрээгээр Хөдөлмөрийн тухай хууль, бусад холбогдох хууль эрх зүйн хүрээнд ажиллуулна.

C.1 Дохиолол хамгаалалт, мэдээлэл зохицуулалтын гэрээт үйлчилгээ

C.1.1 Дохиолол хамгаалалтын үйлчилгээг энэхүү стандартын шаардлага хангасан нөхцөлд холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн мэргэжлийн байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлж болно.

C.1.2 Дохиолол хамгаалалтын үйл ажиллагаа эрхлэх нэгжтэй, тухайн ажил үйлчилгээг гүйцэтгэх чадвартай мэргэжлийн хүний нөөцтэй байна.

C.1.3 Дохиолол хамгаалалтын техник, тоног төхөөрөмж худалдан борлуулах, ханган нийлүүлэх боломжтой, тавьсан тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагааг хангах, засвар үйлчилгээг хийх чадвартай байна.

C.2 Мэдээллийн технологи, харилцаа холбооны гэрээт үйлчилгээний шаардлага

C.2.1 Мэдээллийн технологи харилцаа холбооны зарим үйлчилгээг энэ стандартын шаардлага хангасан нөхцөлд холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн мэргэжлийн байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлж болно.

C.2.2 Мэдээллийн технологи, харилцаа холбооны тоног төхөөрөмж, хангамж, үйлчилгээний инженерийн хэсэгтэй байна.

C.2.3 Мэдээллийн технологи харилцаа холбооны хэсэг нь аюулгүй байдал хамгаалалтын байгууллагын ажилтныг техник тоног төхөөрөмжийн ашиглалт, аюулгүй ажиллагааны заавар, журмаар хангаж, сургалтад хамруулах ажлыг зохион байгуулна.

C.2.4 Мэдээллийн технологи, харилцаа холбооны инженер нь засвар үйлчилгээг төлөвлөгөө, хуваарийн дагуу гүйцэтгэж, техник ашиглалтын тэмдэглэгээг хөтөлнө.

C.2.5 Аюулгүй байдал, хамгаалалтын үйлчилгээнд шаардлагатай, дэвшилтэд технологи бүхий харилцаа холбооны хэрэгслээр бүрэн хангагдсан байна.

C.2.6 Техник технологи, харилцаа холбооны тоног төхөөрөмжийн ашиглалт, эдэлгээ, засвар үйлчилгээний судалгааг жил бүр гаргаж, шинэчлэл хийнэ.

C.3 Хүний нөөцийн менежерийн гэрээт үйлчилгээний шаардлага

C.3.1 Мэргэшсэн, чадварлаг, шуурхай, өндөр бүтээмжтэй баг бүрдүүлэх хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх төлөвлөгөөг эрх бүхий албан тушаалтнаар батлуулан хэрэгжүүлнэ.

C.3.2 Төлөвлөгөө нь энэхүү стандартад дурдсан хүний нөөцийн удирдлагын үндсэн чиг үүргийг бүрэн хамарч 1 жил тутам шинэчлэгдэж, ажилтанд ил тод байна.

C.3.3 Аюулгүй байдал, хамгаалалтын ажилтан, бусад ажилтны хэрэгцээг тооцох, сүл орон тоог нөхөх, ажилтныг мэргэжил, албан тушаалыг нь ахиулах төлөвлөлт /карьер/-ийг ойрын болон дунд хугацаагаар хийж эрх бүхий албан тушаалтнаар баталгаажуулан хэрэгжүүлэлтийг хангасан байна.

C.3.4 Ажлын байрны тодорхойлолт, ажил үүргийн хуваарийг албан тушаал, мэргэжлээр гаргаж, өөрчлөлт орсон тохиолдолд тухай бүр нь шинэчлэн боловсруулж баталгаажуулна.

C.3.5 Хүний нөөцийг бүрдүүлэхэд тухайн ажлын байранд тавигдах шаардлагыг хангасан нэр дэвшигчийг байгууллагын дотроос болон гаднаас ил тод нээлттэй сонгон шалгаруулж ажилд авсан байхыг шаардлага болгоно.

C.3.6 Байгууллагын онцлог, хэрэгцээ шаардлагатай уялдуулан үндсэн орон тоогоор ажиллах шаардлагагүй ажлын байранд тухайн ажлын байрны шаардлагыг хангасан нэр дэвшигчийг сонгон шалгаруулж гэрээгээр ажиллуулж болно.

C.3.7 Ажлын байрны тодорхойлолтыг үндэслэн ажилтан болон ажил олгогч нар хамтран, ажилтныг жил бүр үнэлэх бөгөөд үнэлгээний дүнг бичгээр баталгаажуулан ажилтны хувийн хэрэгт хадгална.

C.3.8 Ажлын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнг харгалзан шагнах урамшуулах, албан тушаал дэвшүүлэх ажлыг ил тод зохион байгуулж, алдаа дутагдлыг арилгах, ололт амжилтыг нийтийн хүртээл болгох ажлыг хэрэгжүүлнэ.

C.3.9 Ажилтнуудын нийгмийн асуудлыг дэмжсэн арга хэмжээг хэрэгжүүлэх бөгөөд ажилтан бүрт адил тэгш байна.

C.3.10 Ажилтанд хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааврыг чанд мөрдүүлж, эрүүл аюулгүй ажлын орчныг бүрдүүлэх, ажлын байран дах осол гэмтлээс сэргийлэх, ажлын байрны стрессийг бууруулах, аюулгүй ажиллагааны соёлыг дэмжсэн арга хэмжээг хэрэгжүүлэн үр дүнг тоофно.

C.3.11 Ажилтныг өөр ажил албан тушаалд шилжүүлэх, томилох, ажлаас чөлөөлөх, хөдөлмөрийн гэрээ цуцлах, дуусгавар болгох, хариуцлага хүлээлгэх, нөхөн төлбөр олгох, ажил амралтын цагийн зохицуулалт, ажилтан хоорондын болон удирдах албан тушаалтан хоорондын харилцаа, ажилтны санал гомдол шийдвэрлэлт зэрэг хөдөлмөрийн харилцаатай холбоотой бусад асуудлыг холбогдох хууль эрх зүйн хүрээнд шийдвэрлэж, шийдвэрийг баталгаажуулан ил тод мэдээлнэ.

C.3.12 Хүний нөөцийн удирдлагын үйл ажиллагааны талаарх бичмэл тайлангаас гадна холбогдох төрийн байгууллагаас батлан гаргасан маягтын дагуу тоон мэдээлэл бүхий тайланг жил бүр гарган байгууллагын ажилтан болон холбогдох эрх бүхий байгууллагад ил тод тайлагнах тогтолцоотой байж хэрэгжилтийг хангасан байна.

C.3.13 Ажилтан бүрт хувийн хэрэг хөтлөх, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн болон цагдаагийн байгууллагаас зөвшөөрсөн хүний нөөцийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийн санг хөтлөн тогтмол баяжилт хийгдсэн байхыг шаардана.

C.3.14 Хүний нөөцийн удирдлагатай холбоотой бүх үйл ажиллагаа, холбогдох бичиг баримтад тодорхой давтамжтай дүн шинжилгээ хийж, тасралтгүй боловсронгуй болгон сайжруулах зорилттой байна.

C.4 Сургалтын гэрээт үйлчилгээний шаардлага

C.4.1 Сургалтын холбогдох чиглэлээр дагнасан байгууллагатай гэрээний үндсэн дээр буюу мэргэжсэн сургагч багштай тусгайлсан гэрээний үндсэн дээр хамтарч ажиллана.

C.4.2 Аюулгүй байдал, хамгаалалтын үйл ажиллагаа эрхэлж байгаа хуулийн этгээд нь ажилтнуудын мэргэжил үр чадварыг дээшлүүлэх зорилгоор сургалтын байгууллагад мэргэшүүлэх, давтан сургалтад хамруулж болно.

C.4.3 Төрийн тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагад ажиллаж байсан, зохих мэргэжил эзэмшсэн иргэнийг гэрээт харуул хамгаалалтын чиглэлийн, төрийн тусгай хамгаалалтын газарт ажиллаж байсан иргэнийг хувийн хамгаалалтын чиглэлийн сургалтад хамруулахыг шаардахгүй.

C.4.4 Мэргэжил олгох сургалтыг чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрөөр явуулж “Чадамжийн гэрчилгээ”-г олгоно.

C.4.5 Аюулгүй байдал, хамгаалалтын ажилтан бэлтгэх, мэргэшүүлэх, давтан сургалт зохион байгуулах зөвшөөрөл авсан хуулийн этгээд нь эрх бүхий байгууллагаас батлан гаргасан сургалтын агуулга, хөтөлбөрийг мөрдөхөөс гадна захиалагч байгууллагын хүсэлтийн дагуу нэмэлт хөтөлбөр боловсруулж болно.

C.4.6 Аюулгүй байдал, хамгаалалтын ажилтан бэлтгэх, ажилтныг мэргэшүүлэх, давтан сургалт явуулж буй хуулийн этгээд нь сургалт дууссаны дараа суралцагсдаас шалгалт авах ба шалгалтыг Цагдаагийн байгууллага, сургалтын байгууллагын хамтарсан бүрэлдэхүүн зохион байгуулна

C.4.7 Шалгалтанд тэнцсэн суралцагчид Хамгаалалтын ажилтны төрөл, мэргэжлийн сургалтад хамрагдсан гэрчилгээг олгож, Хөдөлмөр Нийгмийн Хамгаалалын яам, Цагдаагийн байгууллага бүртгэнэ.

C.4.8 Аюулгүй байдал хамгаалалтын ажилтан бэлтгэх, ажилтныг мэргэшүүлэх, давтан сургалтын үйл ажиллагаа явуулах хуулийн этгээдэд зөвшөөрөл олгох, олгосон тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох асуудлыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу эрх бүхий байгууллага шийдвэрлэнэ.

C.4.9 Аюулгүй байдал хамгаалалтын ажилтан бэлтгэх, ажилтныг мэргэшүүлэх, давтан сургалт явуулах хуулийн этгээд нь эрүүл ахуй, стандартын шаардлага хангасан өөрийн өмчлөлийн эсвэл түрээсээр эзэмшиж буй хичээлийн танхим, бие бялдрыг хөгжүүлэх, тусгай хэрэгсэл, мэх хэрэглэх, бэлтгэл хийх зай талбай бүхий орчин, суралцагчдад хүрэлцэхүйц тооны сургалтын материал, ном сурх бичигтэй байна.

C.4.10 Их дээд сургууль, коллеж, мэргэжлийн боловсрол сургалтын байгууллага, мэргэжлийн холбоодын сургалтын төвд гэрээний үндсэн дээр /дохиолол хамгаалалтын инженер, аюулгүй байдлын мэргэжилтэн, техникч, бие хамгаалагч, дохиолол хяналтын оператор, хяналтын байцаагч, эрсдлийн үнэлгээчин/ ажилтнуудаа захиалгаар бэлтгэж болно.

C.4.11 Аюулгүй байдал, хамгаалалтын ажилтан бэлтгэх, давтан мэргэшүүлэх, сургалт явуулж буй этгээд нь холбогдох хууль, журам, заавар, батлагдсан хөтөлбөрийг мөрдөнө.

C.5 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн гэрээт үйлчилгээний шаардлага

C.5.1 Үйлчлүүлэгч этгээдийн үйл ажиллагаанд хамаарах чиглэлээр хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт зааварчилгааг гэрээгээр гүйцэтгүүлж болно. /Уул уурхай, барилга, химиин болон тэсэрч дэлбэрэх бодисын үйлдвэр, агуулах зэрэг/

C.6 Ажилтны эрх, үүргийн шаардлага

C.6.1 Үйлчлүүлэгчийн хэвийн үйл ажиллагааг тасалдуулж болзошгүй аливаа үйлдэл, нөхцөл байдлыг цаг тухайд нь илрүүлж, таслан зогсоох арга хэмжээ авч эд зүйл, ачаа тээш, мал, амьтан, тээврийн хэрэгсэлд үзлэг хийх, зөрчил гаргагчийн нэр, хувийн байдлыг тодруулж холбогдох байгууллагад нэн даруй мэдээлнэ.

C.6.2 Байгалийн гамшиг, гэнэтийн аюул, гол түймэр, хүн малын гоц халдварт өвчин, үйлдвэрлэлийн осол гарсан үед аврах үйл ажиллагаа болон хорио цээрийн дэглэмийг сахиулахад оролцох, гэм буруутай этгээдийг холбогдох байгууллагад хүлээлгэн өгнө.

C.6.3 Гэмт хэрэг, зөрчлийг таслан зогсоох, арилгах арга хэмжээ авахдаа байгууллага, аж ахуйн нэгж, иргэний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэнэ.

C.6.4 Албан үүргээ гүйцэтгэх үедээ Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн болон Улсын ерөнхий прокурорын хамтран баталсан зааврыг дагуу галт зэвсэг, тусгай хэрэгслийг хэрэглэнэ.

C.6.4 Аюулгүй байдал, хамгаалалтын ажилтан нь үйлчлүүлэгчийн дотоод асуудалд хөндлөнгөөс оролцохгүй, албан үүрэг гүйцэтгэх үедээ олж мэдсэн байгууллага, хувь хүний нууцыг чанд хадгална.

C.6.5 Аюулгүй байдал, хамгаалалтын ажилтан нь нөхцөл байдлыг зөв үнэлж, удирдлага болон холбогдох албадыг үнэн зөв, бодит мэдээллээр хангана.

C.6.6 Аюулгүй байдал, хамгаалалтын ажилтнаар гэрээнд заасан албан үүргээс өөр төрлийн ажил үүрэг гүйцэтгүүлэх, хууль зөрчсөн үйлдэл хийхийг шаардахыг хориглоно.

Д хавсралт
(норматив)

**Байгууллагын зэрэглэл тогтооход тоног төхөөрөмж, багаж,
хэрэгслийн иж бүрдэлд тавих шаардлага**

| № | Тоног төхөөрөмж ба багаж хэрэгслийн шаардлага | Байвал зохих | | |
|-----|--|-----------------|-----------------|-----------------|
| | | “A” зэрэглэл | “B” зэрэглэл | “C” зэрэглэл |
| 1. | Тээврийн хэрэгсэл (Автомашин, мотоцикл, морь) | + | + | + |
| 2. | Түймэр унтраах багаж хэрэгсэл | + | + | + |
| 3. | Богино долгионы станц, | + | + | + |
| 4. | Харуул цагийн систем | + | + | - |
| 5. | Байршил тогтоогч /GPS/ | + | + | - |
| 6. | Зургийн аппарат, видео камер | + | + | - |
| 7. | Согтолт хэмжих багаж | + | + | - |
| 8. | Хурд хэмжигч | + | + | - |
| 9. | Хурд сааруулагч | + | +/- | - |
| 10. | Хэвтээ хаалт | + | +/- | - |
| 11. | Босоо хаалт | + | +/- | - |
| 12. | Холбоо, мэдээллийн иж бүрдэл хэрэгсэл | + | + | +/- |
| 13. | Дохиолол хамгааллын систем | + | + | - |
| 14. | Камерын хяналтын систем | + | + | - |
| 15. | Дуут дохио | + | + | + |
| 16. | Хашааны хамгаалалтын систем | + | +/- | +/- |
| 17. | Домофон систем | + - | +/- | +/- |
| 18. | Автомашины хяналтын систем | + | + | - |
| 19. | Металл илрүүлэгч | + | + | - |
| 20. | Хамгаалах тусгай хэрэгсэл /ком/ | + | + | - |
| 21. | Галт зэвсэг | + | + | +/- |
| 22. | Сум | + | + | +/- |
| 23. | Галт зэвсэг хадталах сейф | + | + | +/- |
| 24. | Галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл | + | + | +/- |
| 25. | Нулимс асгаруулагч буу, шуршүүр | + | + | + |
| 26. | Амьсгал боогдуулагч буу, шуршүүр | + | + | + |
| 27. | Резинэн бороохой | + | + | - |
| 28. | Цахилгаан бороохой | + | + | - |
| 29. | Гав | + | + | - |
| 30. | Гар чийдэн | + | + | - |
| 31. | Энгэрийн камер | + | + | - |
| 32. | Гар чийдэнтэй камер | + | + | - |
| 33. | Чанга яригч | + | + | - |
| 34. | Прожектор | + | + | - |
| 35. | Сум үл нэвтрэх хантааз | + | + | - |
| 36. | Дуулга | + | + | - |
| 37. | Хутганаас хамгаалах бээлий | + | + | - |
| 38. | Бамбай | + | + | - |

1-Р ТАЙЛБАР: “-” шаардахгүй, “+” шаардана, “+/-” шаардаж болно.

2-Р ТАЙЛБАР: Хүснэгтэд дурдсан тоног төхөөрөмжийг холбогдох дагалдах баримт бичгийн товьёгийн хамт бүртгэлжүүлсэн байхыг шаардана.

**Е хавсралт
(мэдээллийн)**

Тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн иж бүрдэлд тавих жишиг шаардлага

E.1 Тээврийн хэрэгсэл

E.1.1.Тээврийн зарим үйлчилгээг стандарт шаардлагыг хангасан нөхцөлд холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн мэргэжлийн байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлж болно.

E.1.2.Аюулгүй байдал, хамгаалалтын үйлчилгээний тээврийн хэрэгсэл нь тоноглогдсон, гав, бороохой тусгай хэрэгсэл, холбогдох стандарт журамд заасан багаж, тоног төхөөрөмжөөр хангагдсан байна.

E.1.3.Тээврийн хэрэгслийн тоо нь үйлчлүүлэгч байгууллагын хамгаалалтын объектын тоо, алслагдсан байдал, үйлчилгээнээс хамааран хүлээгдэлгүй үйлчлэх, хүрэлцэхүйц тооны байна.

E.1.4.Тээврийн хэрэгслийн ашиглалт, эдэлгээ, засвар үйлчилгээний судалгааг жил бүр гаргаж, шинэчлэл хийнэ.

E.2 Гал, түймэр унтраах багаж хэрэгсэл

E.2.1.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага Галын аюулгүй байдлын хууль тогтоомж болон галын аюулгүй байдлын үндсэн дүрэм, норм нормативын бусад баримт бичгийг дагаж мөрднө.

E.2.2.Аж ахуйн нэгж, байгууллага өөрийн ажилтан бүрт галын аюулгүй байдлыг хангах талаар зааварчилгаа өгч, гал түймрээс урьдчилан сэргийлэх, гал түймрийг унтраах, гал түймэр гарсан үед аврах зам, гарц ашиглан хүмүүсийг аюулгүй газарт шуурхай нүүлгэн шилжүүлэх мэдлэг, чадвар олгох сургалтад хамруулж дадлагажуулсан байна. Энэхүү сургалтыг жилд хоёроос доошгүй удаа зохион байгуулж, уг үйл ажиллагааг баримтжуулсан байна.

E.3 Техник, тоног төхөөрөмж

E.3.1.Аюулгүй байдал, хамгаалалтын тоног төхөөрөмжийг үйлдвэрлэгчийн заавар болон аюулгүй ажиллагааны дүрэм журмын холбогдох сургалтад хамрагдсан ажилтан ашиглана.

E.3.2.Аюулгүй байдал хамгаалалтын техник тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа, гарын авлагыг монгол хэл дээр хөрвүүлэн тухайн ажлын байранд харагдахуйцаар бичиж байрлуулна.

E.3.3.Аюулгүй байдал, хамгаалалтын ажилтанд хөдөлмөрийн дотоод журам, ажлын байрны тодорхойлолт, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгааг албан ёсоор танилцуулж баталгаажуулсан байна.

E.4 Тусгай шаардлага

E.4.1.Цацраг идэвхт бодис, хүчил шүлт, цар тахал болон голомтод тахал, тэсэрч дэлбэрэх бодистой объектод ажиллахтай холбоотой эрсдэлийн үнэлгээг хийсний үндсэн дээр, шаардлагад нийцсэн тусгай батлагдсан дүрэм журам зааврыг батлуулж, үйл ажиллагаанд мөрдлөг болгон ажиллана.

E.4.2.Цацраг идэвхт болон тэсэрч дэлбэрэх бодис хий хангамжийн болон дамжуулах системийн аюулгүй байдлын үнэлгээг холбогдох мэргэжлийн байгууллагаар хянуулан баталгаажуулсан байна.

E.4.3.Ажлын байранд “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, ажлын байрны орчин, эрүүл ахуйн шаардлага” стандарт болон Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа бусад стандарт технологийг мөрдөнө.

E.4.4.Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийг үнэлэх, үнэлгээг хийхэд ажилтны оролцоог нэмэгдүүлж, үнэлгээний дүнг үндэслэн хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, хяналт тавьж, үр дүнг тооцно.

F хавсралт
(норматив)

**Байгууллагын хамгаалалтын ажилтны хувцас,
тусгай хэрэгслийн хангалт, ашиглалт**

| № | Хувцас, хэрэглэл | Хэмжи х нэгж | Нэг хүнд ногдох хэрэглэл | |
|---|---|-----------------|---------------------------------|--|
| | | | тоо | Нэг бүрийн элэгдэх хугацаа |
| 1 | Ажлын хувцас (өвөл, зуны хээрийн хувцас) | БАГЦ хослол | 2 | Эрүүл ахуйн болон чанарын шаардлага хангасан, бохирдсон зүйл амархан арилах материалтай байна. |
| 2 | Ажлын костюм (өмд, цамц) | хослол | 2 | Жил бүр хяналт үнэлгээ хийж, дүгнэлт гарган, шаардлага хангахгүй эд зүйлийг актлан, хэрэглээнээс хасаж, нөхөн хангалтыг 2 жил тутам хийнэ. |
| 3 | Тусгай үйлчилгээний ажилтны зориулалтын хувцас, бусад | хослол | 2 | |
| 4 | Хамгаалалтын хувцас, хэрэгсэл | хослол | 2 | |
| 5 | Тусгай шүүлтүүр бүхий амны хаалт | ШИРХЭГ | Хүрэлцэхүйц, илүү нөөцтэй байна | |
| 6 | Зэвсэг, тусгай хэрэгсэл | ТӨРӨЛ | Тоо заахгүй | Тусгай журмаар зохицуулна. |

1-Р ТАЙЛБАР: Ажилтан ажлын хувцас, таних тэмдэгтэй байж материал нь эрүүл ахуйн болон чанар стандартын шаардлагыг бүрэн хангасан байна.

2-Р ТАЙЛБАР: Байгууллагын үйлчилгээний онцлогоос хамааран аюулгүй байдал, хамгаалалтын ажилтан нь галт зэвсэг, тусгай хэрэгслээр бүрэн хангагдсан, зохих дүрэм журмын дагуу хэрэглэх бөгөөд тусгай бүртгэлтэй байна.

**G хавсралт
(мэдээллийн)**

Дэмжих үйлчилгээ үзүүлсэн тухай акт

Огноо: оны-р сарын -ний өдрөөс,
..... оны-р сарын -ний өдөр хүртэл.

Хаана:

Нийт хоног, цаг. Ажилтны тоо.....

Дэмжих үйлчилгээ үзүүлэх шаардлага нь:

.....нэхцэл байсан тул

.....-ээр дэмжлэг үзүүлсэн нь үнэн болно.

Дэмжлэг авсан байгууллагын нэр.....

Баталгаажуулсан албан тушаалтан:

Гарын үсэг: / /

Аюулгүй байдал, хамгаалалтын байгууллагын оноосон нэр.....

Дэмжлэг үзүүлсэн албан тушаалтан /

Гарын үсэг..... /

Ном зүй

1. <https://www.legalinfo.mn/> Монгол Улсын Эрх зүйн мэдээллийн нэгдсэн системээс холбогдох мэдээллийг ашигласан. Үүнд:
 - Үндсэн хууль,
 - Цагдаагийн албаны тухай хууль,
 - Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль,
 - Монгол Улсын Гэрээт харуул хамгаалалтын тухай хууль,
 - Монгол Улсын хувийн хамгаалалтын тухай хууль,
 - Хувь хүний нууцын тухай хууль,
 - Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль,
 - Монгол Улсын Иргэний хууль,
 - Өрсөлдөөний тухай хууль,
 - Байгууллагын нууцын тухай хууль.
2. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2010 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 16 дугаар тушаалаар батлагдсан "Үндэсний ажил, мэргэжил, албан тушаалын жагсаалт, ангилал, тодорхойлолт" YAMAT-08 /ISCO-8/-ын 54 дүгээр дэд бүлгийн 541 дүгээр бага бүлгийн 5414 дүгээр нэгж бүлэг. /5414-11 Гэрээт харуул хамгаалалтын ажилтан, 5414-12 Хувийн бие хамгаалагч, 7422-13 Дохиоллын хамгаалалтын техникч/
3. "Харуул хамгаалалтын үйл ажиллагааг биечлэн гүйцэтгэх боловсон хүчний сургалтын хөтөлбөр", "Сургалтын төлөвлөгөө", "Хяналт тавих журам" /"Хууль зүй дотоод хэргийн сайд, Боловсрол, Соёл шинжлэх ухааны сайд нар 2011 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 107/118 дугаар тушаалаар хамтран баталсан/.
4. "Харуул хамгаалалтын алба хаагч галт зэвсэг нэг бүрийн тусгай хэрэгсэл, зэвсэггүйгээр тулалдах мэх хэрэглэх, албаны нохой ашиглах заавар", "Бие хамгаалагч нэг бүрийн тусгай хэрэгсэл, зэвсэггүйгээр тулалдах мэх хэрэглэх, ашиглах заавар" /"Хууль зүй дотоод хэргийн сайд, Монгол Улсын ерөнхий прокурорын хамтарсан 2003 оны 1 дүгээр сарын 09-ний өдрийн 12/05 тоот тушаалаар баталсан/
5. "Харуул хамгаалалт эрхлэх хуулийн этгээдийг бүртгэх, үйл ажиллагаа явуулах эрхийг түдгэлзүүлэх, бүртгэлээс хасах, үйл ажиллагаанд нь хяналт тавих журам" /Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн A/40 дугаар тушаал/
6. "Хувийн хамгаалалтыг биечлэн гүйцэтгэх боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах, мэргэжлийг нь дээшлүүлэх сургалтын агуулга, төлөвлөгөө", "Хувийн хамгаалалтын сургалт явуулах зөвшөөрөл олгох, үйл ажиллагаанд нь хяналт тавих журам" /"Хууль зүй дотоод хэргийн сайд, Боловсрол, Соёл шинжлэх ухааны сайдын хамтарсан 2018 оны 6 дүгээр сарын 15-ны өдрийн A/119, A/377 дугаар тушаалаар баталсан/
7. "Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм" /Засгийн газрын 2016 оны 339 дүгээр тогтооолоор батлагдсан/